

ТАМГЫН ДАРГА

БАТЛАВ:

Б.БАТЗУЛ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ХАРУУЛ ХАМГААЛАЛТ ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН СИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2024 он

Дархан-Уул аймаг

| № | НЭРТӨРӨЛ, ҮЗҮҮЛЭЛТ | ТОДОРХОЙЛОЛТЫН ШААРДЛАГА |
|---|------------------------------------|--|
| 1 | Техник хэрэгсэл, бараа материал | Изриалын Forse хамгаалалтын тоног төхөөрөмж ашиглан үйлчилгээ үзүүлэх |
| 2 | Стандарт | Дохиолол хамгаалалтын систем нь олон улсын болон Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан байна. |
| 3 | Байршил | <ol style="list-style-type: none"> 1,2,3-р багийн төвийн байр, 4,5,өргөө багийн төвийн байр, 6-р багийн төвийн байр, 7-р багийн төвийн байр, 8-р багийн төвийн байр, 9,10-р багийн төвийн байр, 11,12-р багийн төвийн байр, 13,14,16-р багийн төвийн байр, 15-р багийн төвийн байр |
| 4 | Төсөвт өртөг | Жилийн төлбөр 30,000,000 төгрөг Сарын төлбөр 2,500,000 төгрөг |
| 5 | Төлбөр тооцоо | <ol style="list-style-type: none"> Сар бүрийн 20-ны дотор захиалагч тал төлбөрөө төлөх Тендерийн үнээс өөр нэмэлт зардал захиалагч тал хариуцахгүй. |
| 6 | Тавигдах шаардлага | <ol style="list-style-type: none"> Ажлын хүрээнд мөрдөгддөг батлагдсан дотоод журам, бодлого, ХАБЭА-н журам, заавар зааварчилгаанууд, сургалтын хөтөлбөрүүдтэй байх. Мэргэжлийн боловсон хүчнээ тогтвор суурьшилтай ажиллах боломжоор хангаж гэрээний үүргээ тогтвортой гүйцэтгэж, урамшуулал, амралтын хуваарь нь тогтвортой байх тал дээр анхаарч ажиллах. Харуулын байрны эрүүл ахуйн нөхцөлд онцгой анхаарч ажиллах. Харуул, хамгаалалтын ажилтан бүр ялгах тэмдэг бүхий ХАБЭА-н аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйд нийцсэн, зориулалтын нэгэн жигд хамгаалалтын үйлчилгээний иж бүрэн хувцсаар хангагдсан байх. Хөдөлмөрийн тухай хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуулиудыг хэрэгжүүлж ажиллах. Компанийн барилга байгууламж, эд хогшлын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, компанийн онцгой байдлын үйл |

| | | |
|----|------------------|---|
| | | <p>ажиллагааны зааврыг дагаж мөрдөх, түүнчлэн гэнэтийн халдлага, хулгай, дээрэм зэргээс хамгаалж ажиллах (Харуул хамгаалалтын ажилтан нь амь нас, эрүүл мэнд, ажил мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан байна)</p> <p>7. Харуул, хамгаалалтын ажилтнууд нь нэг бүрийн тусгай хэрэгсэл (гарын гав, резинэн ба цахилгаан бороохой, радио станц /эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөлтэй байх), нулимс асгаруулагч газ, резинэн болон хуванцар сумтай буу, духны болон гар чийдэн/-ээр хангагдсан байх.</p> <p>8. Сонирхсон тендерт оролцогч дохиолол хамгаалалтын системийн үйлчилгээ үзүүлэх байршлуудаар явж газар дээр нь танилцах.</p> <p>9. Харуул хамгаалалтын ажилтан, албан хаагч бүр нь Цагдаагийн байгууллагаас зохион байгуулдаг сургалтад хамрагдсан байх, харуул хамгаалалтын ажилтны гэрчилгээ, сертификат авсан байх.</p> |
| 7 | Ажиллах нөхцөл | <p>1. Үндсэн үйл ажиллагааны дагуу объектуудыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хорлон сүйтгэх, гал түймэр, хулгай, дээрэм бусад аюулын мэдээг зохих байгууллагад цаг алдалгүй мэдээлэх, шаардлагатай арга хэмжээ авч гэрээт харуул хамгаалалтын үндсэн үйл ажиллагааг хийж гүйцэтгэх.</p> <p>2. Харуул хамгаалалтад гарч байгаа ажилтнуудыг тогтвортой ажиллуулах, гэрээ байгуулснаас хойш 12 сарын хугацаанд ажиллах.</p> <p>3. Гүйцэтгэгч нь захиалагчаас баталсан цэг байршлын дагуу хамгаалалтын үйлчилгээ үзүүлнэ.</p> <p>4. Багуудын дохиолол холбооны системийн байнгын найдвартай ажиллагааг хангах.</p> <p>5. Объектод халдлага, галын аюул гарсан, гадны этгээд объектод нэвтэрснийг заасан дохиог дохиоллын МБТ-д хүлээн авмагц оператор шуурхай хэсгийг объект руу илгээж, хэрэглэгч рүү утасдан дуудаж шалтгааныг тодруулна.</p> <p>6. Шуурхай хэсэг түгшүүрийн дохио ирсэн объектод очиж дохиолол ажилласан шалтгааныг тогтоох зорилгоор гаднах үзлэгийг объектод нэвтрэн оролгүйгээр хийнэ.</p> |
| 8 | Хугацаа | Гэрээ байгуулснаас хойш 2024 оны 12-р сарын 31-ны өдөр хүртэл |
| 9 | Туршлага | Харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлсэн 1-аас доошгүй жилийн туршлагатай байх |
| 10 | Тусгай зөвшөөрөл | Харуул, хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх |
| 11 | Санхүүжилт | Урьдчилгаа санхүүжилт олгохгүй |

БОЛОВСРУУЛСАН: НЯГТЛАН БОДОГЧ  Г.РЭНЦЭНДУЛАМ